# ХСҮТ-ИЙН 2025 ОНЫ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А/565 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2020 оны 05 сарын 08-ний өдрийн А/53 тоот тушаалаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албыг шинэчлэн батлуулсан. ЭМС-ийн А566 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэж, хариу арга хэмжээг зохион байгуулж, эрсдэлийн санд бүртгэн дахин давтагдахаас сэргийлэн ажиллах, эрсдэлийн удирдлагыг бүрдүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн төвийн тусламж үйлчилгээнд тохиолдож болох аюул ослыг тодорхойлж, нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлэж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч тохиолдол болохуйц эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллана.

## ЗОРИЛГО: ХСҮТ-ийн 2025 оны эрсдэлийг тодорхойлж, бууруулах төлөвлөгөөний хагас жилийн тайлан

ЗОРИЛТ:

1. Төвийн бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүрт эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнд хэрхэн хариу үзүүлэх нэгдсэн ойлголтын талаар сургалт болон мэдлэг олгох
2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай дүрэм, журам таниулан сурталчилах
3. Тасаг, албаны хоорондох уялдаа холбоог сайжруулах
4. Эрсдэлийг тодорхойлсон, илрүүлсэн нөхцөлд нэн даруй мэдээллэх, арга хэмжээг авч байх
5. Эрсдэл мэдээлэх цахим форумыг идэвхжүүлэх
6. Тохиолдол гарсан үед бүх ажилтан хэрхэн мэдээлэх талаар сургах
7. Тохиолдол гарсан үед хамтарсан багаар шийдвэрлэдэг байх

| Д/д | Болзошгүй эрсдэл | Эрсдэлийг бууруулах арга хэмжээ | Эрсдэлийн ангилал | Эрсдэлийн зэрэглэл | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх албан тушаалтан | Хэрэгжилт | Эрсдэлийн давтамжийн үнэлгээ /хагас жил/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН 6 ЗОРИЛТ /ЭМНЭЛЗҮЙН ЭРСДЭЛ/** | | | | | | | | |
| **ЗОРИЛТ 1: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИН ТОДРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 1 | Үйлчлүүлэгчийг буруу таних эрсдэл | Үйлчлүүлэгчийг зөв таних журамыг хэрэгжүүлж ажиллах, ***тасгийн сургалтыг улирал бүр*** зохион байгуулж, ахлах сувилагчид тайлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх | Өндөр | 8 | Жилийн турш | Арга зүйч, ахлах сувилагч, ээлжийн сувилагч | Тасгийн сургалтаар хийхээр төлөвлөн ажиллаж байна. Тасгийн ахлах сувилагчид хариуцан сургалтыг зохион явуулж одоогоор 3 тасаг /ЭЭТ, ЕМЗ, ЭММЗ/ нийт 25 сувилагчдыг хамруулсан. | 4 |
| 2 | Эрт үеийн анхааруулах үнэлгээний хэрэгжилт тогтмолжоогүйгээс тусламж үйлчилгээ оройтох | ЭҮАУ-ний сургалтыг сувилахуйн албатай хамтран тогтмол зохион байгуулах<br><br>ЭҮАУ-ний самбарын хяналтыг батлагдсан | Өндөр | 9 | I-IV улиралд | ЭМТҮЧА<br><br>СА | 2025.04.18нд ЭҮАУ-ний сургалт нийт сувилагч нарын яриан дээр сургалт орсон.<br>2025.04.23ны өдөр хэвтэн эмчлүүлэх хэсэгт ээлжинд гарч байгаа тасгийн ээлжийн сувилагч нарын дунд Эрт сэрэмжлүүлэх үнэлгээний талаар мэдлэг, самбараа үнэн зөв бөглөсөн эсэх талаар хяналт хийгдсэн | 6 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хувааръ гарган тогтмол хянах | | | | | сувилагч нарын мэдлэг хангалтгүй байсан, давтан үнэлгээ 06.05нд хийгдсэн. | |
| 3 | Бүртгэл мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулахгүй байснаар санхүүжилт хугацаандаа орохгүй байх | Цахим бүртгэгч нарын бүртгэл шивэлтийг тогтмол хянах, алдаа дутагдлыг дор бүр нь залруулах | Өндөр | 10 | I-IV улиралд | ДСА АТ | 2025 оны хагас жилийн байдлаар 8 тохиолдол гарсан. Тухай бүрд тусгайлан сургалт хийгдэж байна. Өмнөх улиралтай харьцуулахад багассан үзүүлэлттэй байна. | 6 |
| 4 | Анхан шатны бичиг баримт бөглөх, дагаж мөрдөөгүйгээс үүсэх ЭЗЭСЛабораторийн тасагт үүсэх эрсдэл | - Ажилтны үүрэг хариуцлагыг ойлгуулах<br>- Ажлын байрны эзэнгүйдлийг арилгах<br>- Лаборант нарийн анхаарлыг дээшлүүлж, тасгийн дотоод хяналтыг тогтмол явуулах<br>-ажилтны идэвхи ажлын байрны хяналтыг сайжруулах<br>-сорьц хүлээн авах, тээвэрлэх журмыг танилцуулж, сургалт явуулах<br>-шинжилгээний хариу илгээх хүлээгэн өгөх журмыг танилцуулж, мэдлэг олгох | Өндөр | 8 | Жилийн турш | ЭЗЭСЛаб | Анхан шатны бичиг баримт хөтлөлтийг давхар шалгаж дотоод хяналт тогтмол хийгдэж байна. Жилийн эцсээр нэгдсэн тайлан гарна. | 8 |
| **ЗОРИЛТ 2: ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦААГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Code blue, шуурхай үйлдлийн багийн үйл ажиллагаа жигдрээгүйгээс хүний амь нас эрсдэх | Краш картын хэрэглээг сайжруулах, бэлэн байдлыг хангаж ажиллах<br><br>Зарлан мэдээллэх системтэй уялдаа холбоотой ажиллах<br><br>Блю кодын журмын талаар сургалт явуулах | Ноцтой | 15 | I-IV улирал д | ЭЭЯТТ | Амилуулах тусламжийн сургалт хуваарийн дагуу үргэлжилж байна. 2025 оны турш төлөвлөгөөний дагуу сургалт хийгдэнэ. | 10 |
| 6 | Үйлчлүүлэгчийн мэдээлэл алдагдах, нууцлал алдагдах | MNS ISO 27001:2021 хэрэгжүүлэх<br><br>Сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын шинэ технологи худалдан авах, ашиглах | Өндөр | 9 | I-IV улирал д | МТА АТ ДСА | MNS ISO 27001:2021 хэрэгжүүлэхээр зөвлөн туслах үйлчилгээ авсан. Цаашид баталгаажилт авахаар төлөвлөсөн. Одоогоор боломжит үнийн санал ирээгүй байна. Байгууллагын мэдээллийг нэг дороос удирдан зохион байгуулж, хянах боломж бүхий Хяналт удирдлагын нэгдсэн систем Active directory-ийн тохируулга хийгдсэнээр төвийн 435 ажилтан уг системд нэвтрэх боломж бүрдсэн. | 6 |
| 7 | Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын ойлголтгүйгээс эрүүл мэндээр хохирох | ХЭМАБ-н тухай сургалт, хяналт хийх | Өндөр | 12 | I-IV улирал д | ХАБ хариуцсан ажилтан БМАБА Эрсдэлийн менежер | ХНХА-тай хамтран Ажлын байрны аюулгүй 10 ажиллагаа, ХАБ сэдэвт сургалтуудыг 4-р сард сургалт хийж, нийт 78 сувилагч, тусгай мэргэжилтэн нар оролцсон | 9 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Ёс зүйн сургалт, мэдээлэл хангалтгүйгээс ажилчид болон үйлчлүүлэгчдийн хооронд үл ойлголцол, харилцааны асуудал үүсэх | Ёс зүйн сургалт эмнэлгийн ажилчдад орох<br><br>Эмнэлгийн орчинд ухуулан сурталчилах мэдээлэл, зөвлөмж байршуулах | Дунд | 6 | I-IV улиралд | Ёс зүйн хороо | ХСҮТ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тасралтгүй зохион байгуулж ирсэн билээ. Уг ажлын хүрээнд ёс зүйн салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургагч багш” бэлтгэх сургалтыг амжилттай зохион байгуулж, 31 эмч, ажилтныг сургагч багшаар бэлтгэлээ. | 6 |
| **ЗОРИЛТ 3: ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 9 | Эмийн гаж нөлөө, урвал хүндрэл өгөх | Эмийн гаж нөлөө илэрсэн үед авах арга хэмжээний бэлэн байдалд байх талаах хичээл орох | Өндөр | 12 | I-IV улиралд | Тасгийн эрхлэгч<br>СА<br>ЭЗА | Гаж нөлөө гарсан тохиолдолд эмч, эм зүйч, сувилагч шар хуудсанд тэмдэглэл хийж, сайтад мэдээллээ бүртгэж, ЭЭЗХХ-р мэдээллэнэ. (1-р улирлын байдлаар 8 гаж нөлөө бүртгэгдсэн) | 12 |
| 10 | Ижил нэртэй, ижил савалгаатай эм тариаг сольж хэрэглэх | Ижил дуудагддаг, ижил савалгаатай эм, тариаг ялгах тэмдэг болон анхааруулгын мэдээллийг байршуулах, сургалт зохион байгуулах | Өндөр | 10 | I-IV улиралд | ЭЗА<br>СА<br>Тасгийн эрхлэгч нар | Эмчлүүлэгчдэд эм тариа солигдож хийгдэх эрсдэлээс сэргийлэн 180-260 эмийн шошго бичдэг. | 8 |
| | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалалтын горимын дагуу зөв хадгалахгүй байснаар эм, эмнэлгийн хэрэгслийн чанар алдагдах | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах<br><br>Тасалгааны температур, чийг, дулаан хэмжигчийн бүртгэлийг тогтмол хийх | Өндөр | 12 | I-IV улирал д | ЭЗА | 2025 оны эхний хагас жилийн байдлаар хадгалалтын горми зөрчсөнтэй холбоотой эм, эмнэлгийн хэрэгслийн чанар алдагдсан тохиолдол гараагүй байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн зөв горимын дагуу хадгалж дотоод хяналт хийгдэж байна. | 8 |
| 12 | Хими эмчилгээний эс хордуулах эмийн тунг буруу тооцоолсноор эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх | Эмчийн заасан тунг эм зүйч хянан шошго бичиж эм найруулагчид өгөх /double check хийх/ | Өндөр | 12 | I-IV улирал д | ЭЗА | Эмчлүүлэгчдэд эм тариа солигдож хийгдэх эрсдэлээс сэргийлэн 180-260 эмийн шошго бичдэг.<br>Эм найрлагын тоо 150-230 байна | 8 |
| **ЗОРИЛТ 4:БУРУУ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД, БУРУУ ТАЛБАЙД, БУРУУ МЭС АЖИЛБАР, ЭМЧИЛГЭЭ ХИЙХЭЭС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 13 | Эмчлүүлэгчид эм тариа дутуу хийх, андуурах эрсдэл | Сувилагч эм тариа дутуу хийх болон андуурч хийхээс сэргийлж ***тасгийн сургалтуудыг улирал бүр*** зохион байгуулж, ахлах сувилагчид тайлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх | Өндөр | 8 | Жилий н турш | Арга зүйч, ахлах сувилагч, ээлжийн сувилагч | Ижил дуудагддаг нэртэй тариа болон ижил харагдах тарианд ялгах тэмдэг, анхааруулгыг Эм зүйн албанаас гарсаны дагуу тасагууд дотоод сургалтуудыг хийсэн.<br>Тасаг бүр эхний хагас жилд тус бүр нэг удаа сургалт зохион явуулсан байна. Нийт 40 орчим ээлжийн сувилагчид хамрагдсан, мөн тасаг бүрийн постонд байршуулахаар дахин захиалсан. | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Цахилгаан эмчилгээ хийгдэх үеээр түлэгдэл үүсэх | Сэргээн засахын эмч цахилгаан эмчилгээний тунг тодорхой бичиж өгөх<br>Цахилгаан эмчилгээ ажиллуулах зааварчилгаа сургалт хийх | Дунд | 6 | Жилийн турш | Г.Цолмон Сэргээн засах тасаг | 2025 оны эхний хагас жилийн байдлаар цахилгаан эмчилгээ хийгдэх үед түлэгдэл үүссэн тохиолдол гараагүй байна. Сэргээн засах эмчилгээний тасаг дотоод сургалт тогтмол хийгдэж байна. | 6 |
| 15 | Өвчтөн, үйлчлүүлэгчийн эд, сорьц солигдох, онош дүгнэлт дутуу, буруу тавигдах, онош дүгнэлт хугацаа алдаж гарах | Авах арга хэмжээ: Арилгах<br>Нэгжийн түвшинд<br>● Бүртгэл хөтлөх, хамтарсан зөвөлгөөн хийж, алдааг залруулах<br>● СҮА3, стандарт, удирдамж мөрдөж ажиллах<br>● Хариуг хянаж, дүгнэлтэнд шаардлагатай өөрчлөлт тусгаж өгөх<br>Удирдлагын түвшинд<br>● Шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх<br>● Лабораторын тоног төхөөрөмж, урвалжийн хангалтыг сайжруулах | Дунд | 4-5 | Жилийн турш | ЭСТ Сорьц авсан/ дүгнэлт зөөвөрлөсөн сувилагч, эд бэлтгэсэн лаборант | СҮА3, стандарт, удирдамж мөрдөж ажиллаж байна. Эмгэг судлаач эмч нарын хамтарсан зөвөлгөөн хийж гадаадын эмч нараас зөвөлгөө авч бүртгэл хөтөлж байгаа.<br><br>Эмгэг судлаач эмчийн дутуу байсан орон тоог нэгээр нэмсэн, бичиг хэргийн ажилтантай болсон. | 4 |
| **ЗОРИЛТ 5: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 16 | Өртөлтийн дараах сэргийлэлтийн хариу арга хэмжээ авах шат дараалал, тодорхой, шуурхай бус | Халдвараас сэргийлэх хяналтын журамд өртөлтийн дараах сэргийлэлтийн зураглал, хариу арга хэмжээний дарааллыг оруулах, шуурхай арга хэмжээг авах боломжоор хангах | Өндөр | 12 | Бүх улирал | ХХСА, эмч ажилтаны эрүүл мэнд хариуцсан ажилтан | Иж бүрдлийн хангалт 100%. Нийт 21 тасаг нэгжийг хангасан. Сургалтыг нийт 120 эмч, 158 сувилагч, тусгай мэргэжилтэн, 44 үйлчлэгч, 30 резидент феллов нарт зохион байгуулсан. Шинэ ажилчдыг Гепатит В вирусийн эсрэг вакцинаар | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байхаас шалтгаалж цусаар дамжих халдварт өртөх | | | | | | дархлаажуулж ажилд нь оруулж байна.2025 оны 05-р сарын байдлаар зүүнд хатгуулсан 5 тохиолдол бүртгэгдсэн. Үүний сувилагч- 1, үйлчлэгч-1, феллов-1, дадлагын оюутан-1, лаборант-1 байсан. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг шуурхай авч дархлал тогтцын үзэж дархлаажуулсан бөгөөд зохих зөвлөмжийг шуурхай өгч ажиллаж байна | |
| 17 | Эмнэлгийн урсгал, хөтөч, мэдээлэл хангалтгүйгээс үйлчлүүлэгч, сахиурын халдвараас сэргийлэх хяналтын дэглэм алдагдах | Халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний талаарх дуугүй хөтөч, тэмдэглэгээг бүрэн хийх, мэдээллийн самбар ажиллуулах | Өндөр | 9 | I-IV улирал д | ХХСА БМАБА АТ СЭЗА | Вашингтоны эмнэлэгт хэрэглэдэг хүрэлцэх анхааруулгыг орчуулан, бэлтгэж, тасаг нэгжүүдийн хэрэглээнд нэвтрүүлсэн. Өрөө болгоны үүд болон дотор талд 6 төрлийн хүрэлцэх анхааруулгын тохирохын байрлуулсан байна  | 8 |
| 18 | Эмнэлгийн ажилчид ажлын байрандаа хурц үзүүртэй зүйл болон зүүнд хатгуулах эрсдэл | Эмнэлгийн ажилчид ажлын байрандаа хурц үзүүртэй зүйл болон зүүнд хатгуулахаас урьдчилан сэргийлэх ***тасгийн сургалтыг улирал бүр*** зохион байгуулж, ахлах сувилачид тайлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх | Өндөр | 8 | Жилий н турш | Арга зүйч, ахлах сувилагч, ээлжийн сувилагч | ХХСА-тай хамтран тасаг бүр дотоод сургалтаар тогтмол сургалт авч байна, мөн хурц зүйлд хатгагдсан тохиолдол эхний хагас жилээр сувилагч 1, лаборант 1, оюутан 1 тус тус байна. Тухай бүрт хатгалтын дараах арга хэмжээг авч ажилласан. | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Эмнэлгийн эмч ажилтаны халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний мөрдөлт хангалтгүй байдлаас ЭТҮХХ-д эмч ажилтануудөртөх | Эмнэлгийн халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний хэрэгжилтийн хувь, түүнд тулгуурласан сургалтын хэрэгцээг тодорхойлж, мөрдөлтийн хэрэгжилтийг хангах | Өндөр | 8 | Бүх улирал | Эмч ажилтаны эрүүл мэнд хариуцсан ажилтан, ХХСА | 2025оны 04-р сарын 28-нд ХСХ-ын орон тооны бус баг хуралдаж. “Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс илүү” уриа дор ХСҮТ-ийн Халдвараас сэргийлэх, хяналтыг сайжруулах 3 сарын аян зохион байгуулаад ажиллаж байна.<br><br>Хагас жилийн байдлаар эмч, ажилчдад ЭТҮХХ-аас сэргийлэх сургалтыг эмч нарт-1 удаа буюу 110 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн нарт 2 удаа буюу 197, үйлчлэгч нарт-1 удаа буюу 45 тус тус орсон.<br><br>ХСХ-ын тушаал хэрэгжилтийн талаар сургалтыг 7хоног бүрийн пүрэв, баасан гарагт орж байна. Сургалтыг одоогоор нийт 4 удаа хийсэн бөгөөд 110 эмч, 125 сувилагч, тусгай мэргэжилтэн, 44 үйлчлэгч, 30 резидент феллов нарт зохион байгуулсан.<br><br>2025 оны 02 сарын 13-с 02 сарын 21-ны хооронд төвийн нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 530 ажилтан хамруулсан.<br><br>Эмч, ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгээр нян тээгчийг илрүүлэх шинжилгээнд хамруулсан бөгөөд 530 ажилтнаас 26 эмч, ажилчдын хамраас МТСА илэрсэн. Нян тээгчээр илэрсэн ажилчдад хлоргексидиний 0,1% хамар хоолой зайлах уусмал, | 15 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хлоргексидиний 4% гар угаах саван, МТСА-ын талаарх гарын авлага, сургалт орж эрүүлжүүлсэн.<br><br>Нийт ажилчдын дархлал тогтоц 100 mIU/ml дээш 458 ажилтан буюу 87% дархлаатай байна.<br><br>Улаанбурхан өвчний талаарх мэдээлэл болон маск зүүж, гараа халдваргүйжүүлэх заавар бүхий санамжийг амбулатори, нийт тасаг, нэгжид нийт 50ш байрлуулсан.лирлын томуугийн вакцинд эмч- 119, сувилагч-57, бусад-74 нийт 250 /47,5%/ ажилтан хамруулсан.<br><br>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 200 ажилтанд зохион байгуулсан.<br><br>Томуу, томуу төст өвчний талаарх мэдээлэл болон маск зүүж, гараа халдваргүйжүүлэх заавар бүхий санамжийн амбулаторий тасагт нийт 25ш байрлуулсан.<br><br>ХСҮТ-д Гепатит В вирустай-22 ажилтан, В,Д хавсарсан-5, С вирустай -53, В,С хавсарсан-4, В,Д,С хавсарсан-4 ажилтан байна. Элэгний эмчийн хяналтанд байдаг бөгөөд жил бүр В, С вирусийн идэвжлийг тодорхойлох шинжилгээнд хамрагддаг. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025оны 05-р сарын байдлаар 19 шинэ ажилтанд чиглүүлэх сургалт орсон.<br><br>Лабораторийн шинжилгээ (ЦЕШ , ШЕШ, B, C вирусийн маркер, бактерлоги) зэрэг шинжилгээнүүдийг бүрдүүлэн ажилд авч байна. B вирусийн дархлаажуулалтанд хамрагдаагүй ажилчдыг ХӨСҮТ дээр дархлаажуулалтанд хамруулан ажилд авч байна.<br><br>Гепатит B вирустай-1 ажилтан, Syphilis /TPH+/-2 ажилтан оношлогдож ХӨСҮТ-д эмчилгээнд хамрагдаж эмчлэгдсэн.<br><br>Ажилчдын нян тээгчийн шинжилгээгээр 2 ажилтнаас МТСА илэрсэн. Нян тээгчээр илэрсэн ажилчдад хлоргексидиний 0,1% хамар хоолой зайлах уусмал, хлоргексидиний 4% гар угаах саван, МТСА-ын талаарх гарын авлага, сургалт орж эрүүлжсэн. | |
| 20 | Лабораторийн химийн бодистой удаан хугацаагаар ажиллах / химийн урвалж бодист хордох, түлэгдэх / аутопсийн | Авах арга хэмжээ: Арилгах Нэгжийн түвшинд+ Халдвар хяналтын алба+Байгууллагын удирдлага<br>● Агааржуулалтын систем сайжруулах | Дунд | 2-5 | Жилийн турш | Байгууллага, тасаг нэгжийн удирдлага, ЭСТ | Тасгийн бүх ажилчид ХСҮТ-н нийт ажилчдын Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. | 4 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ хийхтэй холбоотой / хорт бодис ялгарах /, байнгын суугаа ажилтай холбоотой мэргэжлээс шалтгаалах өвчин эмгэг үүсэх | ● Тасгийн аюулгүй ажиллагааны нөхцлийг үнэлүүлэх<br>● Ажлын цагийн хуваарт өөрчлөлт оруулах<br>● Амралтын өрөөг тохижуулах шаардлагатай<br>● Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | | | | | | |
| 2 1 | Өвчтнөөс авсан, эд сорьцыг бэлтгэх явцад халдвар авах | Авах арга хэмжээ: Арилгах Нэгжийн түвшинд+ Халдвар хяналтын алба<br>● Халдвар хяналтын албатай хамтран ажиллаж өртөлийн цомог болон бусад шаардлагатай цомог үүсгэх, бэлэн байдал хангах, сургалт авах<br>● Бүртгэл хөтлөлт хийх<br>● СҮАЗ мөрдөж ажиллах | Бага | 2 | Жилийн турш | Сорьц бэлтгэсэн лаборант, онош дүгнэлт тавьсан эмч | Эмнэлгийн тусламж үйлчилгээний тохиолдлын бүртгэл (moh.gov.mn)-д бүх ажилчдын бүртгэл хийж тохиолдол бүрийг нэгдсэн санд бүртгэх боломжтой болсон. ХХСА өртөлтийн цомгийг нэгдсэн байдлаар захиалга өгсөн. | 2 |
| **ЗОРИЛТ 6: ЭМНЭЛГИЙН ОРЧИНД УНАХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 2 2 | Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилчид явганаас болон орноос унах эрсдэл | “Үйлчлүүлэгчийн унах эрсдэлийг үнэлэх” журмыг хэрэгжүүлж ажиллах, ***сургалтыг жилд 2 удаа*** зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийх | Өндөр | 8 | Жилийн турш | Арга зүйч, ахлах сувилагч, ээлжийн сувилагч | Эхний хагас жилийн сургалтыг 6-р сарын 20-нд нийт сувилагчдын дунд зохион явуулахаар төлөвлөсөн байна. | 6 |
| **ЭМНЭЛГИЙН ОРЧИНД ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДАД ТОХИОЛДОЖ БОЛОХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | | | |
| 2 3 | Эмнэлгийн хоол бэлтгэж байх үед түлэгдэх, гэмтэх, унах, гараа зүсэх | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллах, зааварчилгаа | Өндөр | 12 | I-IV улиралд | ЭХШТТ | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллах, зааварчилгааг өдөр бүр өгөн гарын үсэг зуруулан ажиллаж байна. Хоол хийх явцад бэртсэн, гэмтсэн | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өгөх, сургалт зохион байгуулах | | | | | тохиолдлыг бүртгэж тухай бүрт арга хэмжээ аван, Ажилтны эмч Мөнхжаргалд үзүүлэн ажиллаж байна. 2025оны эхний хагас жилд бэртсэн тохиолдол гараагүй байна. | |
| 24 | Цацраг туяанд хэт хордох | Хамгаалах хувцас, хэрэглэлийг стандартын дагуу тогтмол хэрэглэх<br><br>Дозметр байнга зүүж хэвших | Өндөр | 9 | I-IV улиралд | Цацраг аюулгүй байдлын алба | Эмч ажилчид дозиметр зүүж, сар тутамд цацрагийн хэмжилт хийлгэж байна. | 8 |
| 25 | Гар засал эмчилгээний үеэр механик гэмтэл авах | Эмчилгээг зөв техникээр хийх<br>Эмчилгээнд туслах хэрэгслүүдийг ашиглах | Өндөр | 9 | 2024.12.02 | Ц.Цолмонбаяр | 2025оны 6сарын 6ны байдлаар гар засал эмчилгээ хийж байх явцад бэртэл авсан тохиолдол гараагүй байна. Ц.Цолмонбаяр гар засал эмчилгээний 3кр сургалтанд хамрагдсан. Зөв техникийн дагуу эмчилгээг хийж байна. | 6 |
| 26 | Хоол хийх технологи ажиллагаа алдагдах | Эмчилгээний хоолыг цэс, технологийн дагуу хийж хэвших | Дунд | 6 | I-IV улиралд | Тогооч, бэлтгэгчнар | Эмчилгээний хоолыг цэс, технологийн дагуу хийж хэвшин ажиллаж байна. Хоол хийх технологийн карт боловсруулж ажиллаж байна. Эмчилгээний хоолны цэсийг ЭЭДЗ-р батлуулан хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна. | 4 |
| 27 | Өвчтнөөс авсан, эд сорьцыг бэлтгэх явцад гэмтэж бэртэх | Авах арга хэмжээ: Арилгах Нэгжийн түвшинд+ Халдвар хяналтын алба<br>● Халдвар хяналтын албатай хамтран ажиллаж өртөлийн цомог болон бусад шаардлагатай цомог үүсгэх, бэлэн байдал хангах, сургалт авах | Бага | 3 | Жилийн турш | ЭСТ Сорьц бэлтгэсэн лаборант, онош дүгнэлт тавьсан эмч | Эмнэлгийн тусламж үйлчилгээний тохиолдлын бүртгэл https://eburtgel.hdc.gov.mn/login)-д бүх ажилчдын бүртгэл хийж тохиолдол бүрийг нэгдсэн санд бүртгэх боломжтой болсон. ХХСА өртөлтийн цомгийг нэгдсэн байдлаар захиалга өгсөн. | 3 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ● Бүртгэл хөтлөлт хийх<br>● СҮАЗ мөрдөж ажиллах | | | | | | |
| **2. ЭМНЭЛЗҮЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ** | | | | | | | | |
| **2.1. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ** | | | | | | | | |
| 28 | Хүчилтөрөгчийн баллонтой өвчтөн зөөвөрлөх явцад болон хошууг холбох үед өрөөний шалан дээр санамсаргүй баллоныг унагаж тэсэрч дэлбэрэх | Зөөврийн хүчилтөрөгчийн баллонд бэхэлгээ хийх, хяналт тавих<br><br>Хүчилтөрөгчийн баллонтай харьцахдаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх.<br><br>Энэ талаар сургалт зохион байгуулах | Өндөр | 10 | I-IV улирал д | Нийт ажилчид ЭТТА | Зөөврийн хүчилтөрөгчийн баллонд бэхэлгээ хийх, хяналт тавин ажиллаж байна. Мөн хүчилтөрөгчийн баллонтай харьцахдаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдүүлэн ажиллаж байна | 8 |
| 29 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа дутуу байдлаас ажлын байрны осолд өртөх | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг хэвлэж, байршуулах, сургалт зохион байгуулах | Өндөр | 9 | I-IV улирал д | ЭТТА | ЭТТАлбаны инженерүүд хуваарийн дагуу өөр өөрсдтийн хариуцсан хэсгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дэвтрийн бөглөн хяналт тавин ажиллаж байна. | 8 |
| 30 | Ариун цэврийн өрөө шаардлага хангасан суултуургүй, бариулгүйн улмаас унах, бэртэж гэмтэх | Аюулгүйн тойрон үзлэгийг тогтмол хийх<br><br>Ариун цэврийн өрөөнд түших, дэмжлэг болох бариул, шаардлага хангасан суултуур байрлуулах, гэрэлтүүлэгийг хангалттай байлгах | Өндөр | 8 | I-IV улирал д | ХХСА БМАБА Ахлах сувилагч нар Эрсдэлийн менежер | Тасгуудын үйлчлүүлэгчийн ариун цэврийн өрөөнд урсгал засвар хийгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандартын бариулаар тоноглогдсон. | 6 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТХМЗ тасгийн үйлчлүүлэгчдийн 00-с эхлэн жишиг шинэчлэлт хийх | | | | |  | |
| 31 | Лабораторийн эд боловсруулах дамжлагын тоног төхөөрөмж эвдрэх | Авах арга хэмжээ: Арилгах/ залруулах<br>Нэгжийн түвшинд+ Байгууллагын удирдлага<br>● Тоног төхөөрөмжийг засварлуулах, бүртгэл хөтлөлт хийх<br>● Шинээр авах (ажиллах боломжгүй тохиолдолд/ эвдрэл хэт олон давтагдсан тохиолдолд)<br>● Гар аргаар дамжлагын үргэлжлүүлэх<br>● СҮАЗ мөрдөж ажиллах | Дунд | 5 | Жилийн турш | Сорьц бэлтгэсэн лаборант, нийлүүлэгч байгууллагын инженер | Хариуцсан инженерээр засварлуулан, бүртгэл хөтлөлт хийж байгаа. | 5 |
| 32 | Микроскопи, компьютер зэрэг бусад тоног төхөөрөмж эвдрэх, саатах | Авах арга хэмжээ: Арилгах/ залруулах<br>Инженер техникийн алба+ IT алба+Байгууллагын удирдлага<br>● Бүртгэл хөтлөлт хийх, алдааг олж, засварлуулах<br>● Шинээр авах (ажиллах боломжгүй тохиолдолд/ эвдрэл хэт олон давтагдсан тохиолдолд) | Дунд | 4 | Жилийн турш | Эмч, эс судлаач, лаборант | ЭСТ-н микроскопууд эдэлгээний явцад гэрэл хэт тод шар туяатай болсон, /Туйлшруулагч шилийг төстэй шилээр орлуулж хэрэглэж байгаа/, Объектив окулярын шилэнд нарийн тоос орсон. Окулярын өндөр өсгөлтөнд фокус таарахгүй болсон үүний үр дүнд шинжилгээнд дүгнэлт өгөхөд багажийн алдаа гарах, мөн хэрэглэж байгаа эмч, эс судлаач нарын нүдний эрүүл мэндэд ачаалалт өгөх, цаашлаад сургалтын зориулалттай ашиглах | 4 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | микроскоп байхгүй зэргийг үндэслэн Инженер техникийн алба болон Байгууллагын удирдлага байгууллагийн нөөцийн хэмжээнд тасгийн микроскопыг шинэчлэх шийдвэр тендерийн шатанд явж байна. | |
| 33 | Эмнэлэгийн нэгдсэн цахим сүлжээ тасрах доголдох | Авах арга хэмжээ: Арилгах/ залруулах Инженер техникийн алба ● Мэдээллэх | Дунд | 4 | Жилийн турш | Инжинер техникийн ажилтан | Эмнэлгийн сүлжээг засварлах болон түр тасрахтай холбоотой мэдээллийг тухай бүрт нь өгж сайжруулалт хийн, ажил үүргийн хуваарьт зохицуулалт хийн ажиллаж байна. | 4 |
| 34 | Сувилагч ТМ нар ажлын байрны ХАБ эрсдэл | Сувилагч ТМ ажлын байрны ХАБ-ын ***сургалтыг жилд 2 удаа*** зохион байгуулах, анхааруулга гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх | Дунд | 4 | Жилийн турш | Арга зүйч, ХАБ мэргэжилтэн | ХНХА-тай хамтран Ажлын байрны аюулгүй 10 ажиллагаа, ХАБ сэдэвт сургалтуудыг 4-р сард сургалт хийж, нийт 78 сувилагч, тусгай мэргэжилтэн нар оролцсон | 4 |
| 35 | Ханын хүчилтөрөгчийн хүрэлцээ муу | ЦХМЗ тасгийн Б талын эхний 4 палатанд ханын хүчилтөрөгийг байрлуулах | Дунд | 6 | 2025 оны турш | ЭТТА ЦХМЗ | 2025 сүүлийн хагаст МЗТасгийн Б хэсэг, ТХМЗТасгийн бүх өрөөнд ханын хүчлтөрөгч байрлуулахаар байгууллагын төлөвлөлтөнд тусгагдсан байна. | 8 |
| 36 | Ус болон агаар дамжуулах хоолой эвдрэх | Авах арга хэмжээ: Зайлсхийх Инженер техникийн алба ● Мэдээллэх ● Улирал, хагас жил, жил бүр тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгах, урсгал завсар хийх | Бага | 3 | Жилийн турш | Инжинер техникийн ажилтан | 2025 оны байдлаар ус болон агаар дамжуулах хоолой эвдэрсэн тохиолдол байхгүй. Тогтмол урсгал засваруудыг хийж байна. | 4 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | Лабораторит хэрэглэгдэж буй будаг урвалж асгарах | Авах арга хэмжээ:<br>Зайлсхийх<br>Нэгжийн түвшин<br>● Асгарсан бохирдол арилгах (зохих журмын дагуу)<br>● Бүртгэл хөтлөлт хийх<br>● СҮАЗ мөрдөж ажиллах | Бага | 3 | Жилийн турш | Сорьц бэлтгэсэн лаборант | Хариуцсан лаборант асгарсан бохирдлыг арилгаж, бүртгэл хөтлөлт хийж байгаа. | 4 |
| 38 | Шарил шатаар зөөх явцад унагах эрсдэл | Цахилгаан шатыг ажилд оруулах санал байгууллагын захиргаанд байнга сануулах | Бага | 3 | Жилийн турш | ХөЭТ | Хөнгөвчлөх эмчилгээний тасаг засварын ажилтай холбоотой туяа эмчилгээний тасаг, Сэлбэ эмнэлэгт түр хугацаагаар шилжин ажилаж байна. Цаашид орчин нөхцөл сайжрахаар зохион байгуулалт хийгдэж байна. | 4 |
| **2.2. БАЙГАЛИЙН БУЮУ ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГАМШИГ** | | | | | | | | |
| 39 | Гал түймэр гарах | МУ-ын Галын аюулгүй байдлын тухай хууль, ХСҮТ-ийн галын аюулгүй байдлын журам-ыг мөрдөж ажиллах<br><br>Гамшгийн хорооноос галын аюулын үеийн сургалт тогтмол явуулах<br><br>Онцгой байдлын албанаас явуулдаг сургалтыг жилд 1 удаа хэрэгжүүлэх<br><br>Гарцын схем шинэчлэх, галын аврах схемийг ил байршуулах | Өндөр | 10 | I-IV улиралд | Гамшгийн хороо БМАБА СЭЗА Эрсдэлийн менежер | МУ-ын Галын аюулгүй байдлын тухай хууль, ХСҮТ-ийн галын аюулгүй байдлын журам-ыг мөрдөж ажиллаж байна.<br>Гамшгийн хорооноос галын аюулын үеийн сургалт тогтмол явуулдаг.<br>Онцгой байдлын албанаас явуулдаг сургалтыг жилд 1 удаа хэрэгжүүлдэг.<br>Гарцын схем шинэчлэх, Галын аврах схемийг ил байршуулсан.<br>Галын аюулын үеийн бэлэн байдлын хэрэгслүүдийг шинэчлэх, хяналт тавих ажилтан томилох шаардлагатайг БМАБА-д хүргүүлсэн.<br>Аврах гарцны чиглэл заасан сумыг байрлуулсан.<br>Гал гарсан тохиолдолд ХҮИТА руу мэдээлэх, 101 яаралтай дуудах мөн | 10 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Галын аюулын үеийн бэлэн байдлын хэрэгслүүдэд хяналт тавих<br><br>Аврах гарцны чиглэл заасан сумыг байрлуулах<br><br>Гал гарсан тохиолдолд шуурхай удирдлага руу мэдээлэх, 101 яаралтай дуудах | | | | | зарлан дуудах системийг ажиллуулдаг. | |
| 40 | Газар хөдлөлт | Газар хөдлөлтийн үед ажилтан, албан хаагчид барилгын гадна цугларах аюулгүй газрыг тодорхойлох, мэдээлэх<br><br>Иргэдэд газар хөдлөлт, гамшгаас сэргийлэх, өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх | Өндөр | 10 | I-IV улиралд | Гамшгийн хороо БМАБА СЭЗА Эрсдэлийн менежер | 2025.03.27- ны өдөр 16.00 цагт Гэнэтийн газар хөдлөлтийн үед аврах ажиллагааг зохион байгуулах дуут дохиогоор ажиллах дадлага сургууль болох тул төвийн бүх ажилчин албан хаагчид гэнэтийн ослын дуут дохиогоор төв талбайд цугларч дадлага хийгдсэн.<br> | 8 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | Үер | Үерт өртсөн болон усанд живсэн үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах<br><br>Үерийн гамшгийн үед зайлшгүй шаардлагатай ус сорох насос, гутал, бээлий, эм багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх<br><br>Дээврийн хучлагыг шалгах, шаардлагатай үед засварлах | Өндөр | 10 | I-IV улиралд | Гамшгийн хороо БМАБА СЭЗА Эрсдэлийн менежер | Үерийн гамшгийн үед зайлшгүй шаардлагатай ус сорох насос, гутал, бээлий, эм багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн.<br>Үерийн ус нэвтрэх магадлалтай газруудад шуудуу татсан. | 10 |
| 42 | Цацрагийн аюулгүй байдал | Цацрагийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах<br><br>Тогтмол хяналт хийх | Өндөр | 10 | I-IV улиралд | Цацрагийн алба ЭЗЭДЗ ТЭТ | Цацрагийн аюултай нөхцөлд ажиллдаг ажилчдад хамгаалалтын хэрэгсэл болон дозиметрээр хангаж сар тутам хэмжилт хийлгэн ажиллаж байна.<br>Жил бүр ажилчдад мэргэжлээс шалтгаалах өвчний үзлэг оношлогоонд хамрагддаг. | 10 |
| 43 | Гоц халдварт өвчин дэгдэх | Халдварын үед хэрэглэх эм тариа, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлэх<br><br>Халдварын үед ажиллах үзүүлэх сургууль явуулах<br><br>Бэлэн байдлын эрсдэлийн үнэлгээ хийх | Өндөр | 10 | I-IV улиралд | ХХСА ЭМТҮЧАБА ЭЗА | Халдварын үед хэрэглэх эм тариа, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэглэлийн нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг хангаж ажилладаг. | 10 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | Тог тасрах, цахилгааны хомсдолын үеийн бэлэн байдал | Тог баригч ашиглах, тогны эх үүсвэр бий болгох | Дунд | 6 | I-IV улирал д | МТА БМАБА | 5-р сарын 30-нд эхний хагас жилийн сургалтыг авсан. Аппарат тоног төрөөхөрмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа сэдэв сургалтыг хийж нийт 92 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. | 6 |
| 45 | Сувилагч орон тооны хомсдол үүсэх эрсдэл | Сувилагч ажлын ачаалалд ядрах эрсдэлтэй, шинэ сувилагч нарыг сонгон авах ажлыг сувилагч бэлтгэн төгсгөж буй сургуулиудад зохион байгуулж, хүний нөөцийг тасралтгүй нэмэгдүүлж байх | Дунд | 6 | Жилий н турш | Захиргаа Сувилахуй ин алба ХНХА | 2025 оны 4 сарын 10, 11, 18-нд болон 5 сарын 1-ны өдрүүдэд нийт 4 удаа “Ажлын байр суртачлах” өдөрлөг зохион байгуулсан. Энэ өдөрлөгт АШУҮИС Сувилахуйн сургууль, ЭТҮГЭН ИС Сувилахуйн сургууль, ОУИС-ын Сувилахуйн сургуулийн төгсөх курсийн оюутнууд хамрагдсан. Өдөрлөгт нийт 155 оюутан хамрагдаж, ажилд орох хүсэлтийн анкетыг 62 оюутан бөгөлсөн байна. | 6 |
| 46 | Хүний нөөцийн дутмаг байдал | Авах арга хэмжээ: Арилгах Байгууллагын удирдлага Шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх (эмч, лабораторийн техникч, бичиг хэргийн ажилтан, эмгэг судлалын туслах ажилтан) | Дунд | 4 | Жилий н турш | Тасгийн эрхлэгч, байгууллагын удирдлага | Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг стратеги бодлоготой уялдуулан 2000–2005 он, 2006-2008 он, 2009-2011 он, 2012-2014 он, 2015-2017 он, 2019-2020 он, 2021-2023 онуудад үе шаттай тодорхойлон хэрэгжүүлж байна. 2024-2026 онд “Хавдар судлалын үндэсний төвийн хүний нөөцийн бодлого”-ыг төлөвлөн ажиллаж дагалдах төлөвлөгөөнүүдийг боловсруулж хэрэгжүүлэн ажилласан. | 4 |
| **2.3. САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТРАГЧ ТАЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | Өндөр өртөгт багаж, хэрэгслийн хомсдол | Захиалга болон нийлүүлэлтийг тогтвортой байлгах | Дунд | 6 | Жилийн турш | Мэс заслын тасгууд Эм зүйн алба ХСҮТ-ийн санхүү | Эрүүл мэндийн яамны хүрээнд эмнэлгүүдийн тендерийг цуцлан эм ханган нийлүүлэх хороо байгуулахаар ажиллаж байна. Одоогоор тасалдал үүссэн тохиолдол гарсан хэвээр байна. | 6 |
| 48 | Эмнэлэгт, эмнэлгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх эд зүйлс, бараа материалын хомсдол, дутагдал үүсэх | Захиалга болон нийлүүлэлтийг тогтвортой байлгах | Дунд | 6 | Жилийн турш | Мэс заслын тасгууд Эм зүйн алба ХСҮТ-ийн санхүү | Гэрээ дууссан, тендерийн тоо гүйцсэн шалтгаанаар эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэх эрсдэлийг эм зүйн албаны нөөцийн тасаг урьдчилан мэдээлэн ажиллаж байна | 6 |
| 49 | Нийт сувилагч, ТМ нарт ажлын хувцасаар хангахгүй байх эрсдэл | Захиалсан хувцас ирэхгүй байх, хойшлогдох, шаардлага хангахгүй хувцас ирэх зэрэгт анхаарч ажиллах | Бага | 4 | Жилийн турш | СЭЗА СА | Энэ жилд нийт сувилагч, тусгай мэргэжилтэн нарт шинэ хувцасны захиалга бүтэн хийгдээгүй, харин 2025 оны ажлын хувцасны захиалганд шинээр ажилд орох сувилагч, тусгай мэргэжилтний нийт 110ш өмд цамцны захиалга хийж, тендерт оруулсан. | 4 |

Эрсдэлийн үнэлгээ буурсан - 20
Эрсдэлийн үнэлгээ хэвэндээ - 25
Эрсдэлийн үнэлгээ нэмэгдсэн - 4

Төлөвлөгөөг нэгтгэсэн ЭМТҮЧАБА Аюулгүй байдал эрсдэл хариуцсан менежер .....Б.Мандхай

Төлөвлөгөөг хянасан ЭМТҮЧАБАлбаны дарга.....Б.Баасанжав